

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.							
1.1. Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.							
1.1.1.	Залуучуудыг бизнес эрхлэлтийн сургалтад хамруулах	ХЭДС 220,0	Гарааны бизнесийн сургалтад хамрагдсан залуучуудын тоо	480	750	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулж нийт 472 залуучуудыг бүртгэж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан нэг дэх үе шат буюу “Гарааны бизнесээ эхлүүлэх” 72 цагийн арга хэмжээнд 309 залуучуудыг хамруулж, хоёр дахь үе шат буюу “Бэлтгэл хурдасгуур” арга хэмжээнд 62 багийн 137 залуучуудыг менторын тусламжтайгаар бизнес санаагаа хөгжүүлэх, харилцан биенээсээ суралцах үйл ажиллагааг 5 долоо хоног буюу 2021.09.02-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан. Арга хэмжээний 3 дахь үе шат буюу Хөрөнгө оруулагчид төслөө танилцуулах арга хэмжээг “Баянхошуу дэд төв”-д 2021.09.07-2021.09.09-ны өдрүүдэд зохион	90%

1.1.2	Гарааны бизнесийн санааг хөгжүүлж, шалгарсан төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх		Санхүүгийн дэмжлэг авсан багийн тоо	13	21	байгуулж, 42 багийн 94 залуучууд өрсөлдсөнөөс шилдэг Старт-ап 18 баг шалгаран тус бүр 10 сая төгрөгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлгүйгээр авсан. Мөн Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн вакумжуулсан сургалтад хамрагдсан 793 оролцогчдыг “Залуучуудыг гарааны бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх” сэдвээр сургалтад хамруулж нийт 1377 залуус гарааны бизнес эрхлэлтийн сургалтад хамрагдсан байна.	90%
Гүйцэтгэлийн зорилт 1.2. Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж, орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.							
1.2.1.	Цагийн ажлын байр бий болгосон ААНБ-ын хамтын ажиллагааг сайжруулж, хамтран ажиллах	ХЭДС 49.0	Ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийн тоо	462	500	1. Тус байгууллагын дэргэдэх “Цагийн ажлын бирж” нь оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд 18 их, дээд сургуулийн дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-тэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 454 ажил олгогч байгууллагаас 6098 цагийн ажлын байрны захиалга хүлээн авсан.	90%
			Цагийн ажилд хамрагдсан оюутан залуучуудын тоо	5864	7000	2. Тайлант хугацаанд цагийн ажил хийх хүсэлтэй 6726 оюутан, залуусыг бүртгэн, 6048 оюутан, залуусыг түр болон цагийн ажлын байраар хангасан байна.	
1.2.2.	Их, дээд сургууль, Политехникийн коллежийн дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, хамтран ажиллах			тоо	18	18	Их, дээд сургууль, коллежийн дэргэдэх Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 18 төвтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжин ажиллаж байна. Тус төвүүдээс ирсэн 3220 оюутны хүсэлтийг хүлээн авч улирлын чанартай ургац хураалтын ажилд зуучлан цагийн ажлын байраар хангасан.

						“Цагийн ажлын бирж” цахим хуудсаар дамжуулан нээлттэй ажлын байрны мэдээллүүдийг тогтмол хүргэж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 10 удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж 1100 оюутан, залуучуудыг хамруулсан.	
1.2.3.	Хөдөлмөрийн өдөрлөг яармаг зохион байгуулах		тоо	2	2	<p>“ЦАХИМ ТӨГСӨЛТ-ЦАХИМ АЖЛЫН БАЙР” өдөрлөгийг Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Эйч Ар клуб” ТББ-тай хамтран CAREER EXPO платформд цахимаар зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг дороос хүргэлээ.</p> <p>Өдөрлөгийн хүрээнд тус платформд 184 ажил олгогч байгууллагын 2129 ажлын байр нээлттэй зарлагдаж, 88 их, дээд сургууль, коллежийн 1051 төгсөгч ажил хайгчаар бүртгүүлсэн ба 1019 оюутан цахимаар цаг товлон, ажлын шууд ярилцлагад орсон.</p> <p>Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн хүрээнд Ажил олгогчтой хийх уулзалт, хөдөлмөрийн яармагийг 8 удаа зохион байгуулж, 175 ажил олгогчийг оролцуулж, 7422 нээлттэй ажлын байрыг танилцуулснаас 873 оролцогч ажил олгогчтой дадлагажих гэрээ байгуулсан.</p>	90%
Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.							
Гүйцэтгэлийн зорилт 1.3. Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн систем болон цахим хөдөлмөрийн биржийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.							
1.3.1.	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын бий болгосон шинэ ажлын байрыг хөдөлмөр	-	тоо	6632	5000	Ажил олгогчоос ирүүлсэн мэдээллийн дагуу нийслэлийн хэмжээнд шинээр бий болсон 6961 ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв. Шинээр бий болсон ажлын байрыг	90%

	эрхлэлтийн байгууллагуудаар дамжуулан бүртгэх					<p>дүүргээр харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> • Багануур 126 • Баянгол 648 • Баянзүрх 1611 • Багахангай 24 • Налайх 154 • Сонгинохайрхан 1771 • Сүхбаатар 1062 • Хан-Уул 800 • Чингэлтэй 765 	
1.3.2.	Шинэ болон байнгын ажлын байр олноор бий болгосон аж ахуйн нэгж байгууллагыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	тоо	-	4	<p>Шинэ болон байнгын ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж байгууллагуудыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг дараах байдлаар зохион байгуулан хэрэгжүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсуудад шинэ ажлын байр бий болгосон болон ажлын байрны захиалга ирүүлсэн 183 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг байршуулсан. - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр дамжуулан ажил олгогчийг дэмжих зорилгоор Хүний нөөцийн бүрдүүлэлтийн аяныг 18 удаа зохион байгуулж 1132 ажлын байр зарлагдаж, 768 ажил хайгч иргэн ажлын ярилцлагад орсноос 549 иргэн ажилд орсон. Өдөрлөгийн талаарх мэдээллийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын цахим хуудсанд тогтмол мэдээлж, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагыг сурталчлан ажилласан ба мэдээллийг 53498 иргэн үзэж сонирхсон байна. - “Хөдөлмөрийн цахим яармаг-2021” арга хэмжээнд 183 ажил олгогч байгууллагыг 	90%	

						<p>оролцуулсан ба ажлын байрны мэдээлэл, танилцуулгыг 15,515 хүн үзэж танилцсан.</p> <p>- Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн хүрээнд Ажил олгогчтой хийх уулзалт, хөдөлмөрийн яармагийг 8 удаа зохион байгуулж, 175 ажил олгогчийг оролцуулж, 7422 нээлттэй ажлын байрыг танилцуулснаас 873 оролцогч ажил олгогчтой дадлагажих гэрээ байгуулсан ба тус үйл ажиллагааг мөн олон нийтэд сурталчлан ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллалаа.</p>	
1.3.3.	"Хөдөлгөөнт бирж" үйл ажиллагааг алслагдсан хороо, дүүргийн иргэдэд хүргэн ажиллах		тоо	-	4	<p>"Хөдөлгөөнт бирж" үйл ажиллагааг 2021 оны 09 дугаар сарын 07-ний өдрөөс 09 дугаар сарын 16-ны өдрийн хооронд алслагдсан хороодын 5 байршилд зохион байгуулж 500 гаруй иргэдэд танилцуулга материал тараан, үйл ажиллагаагаа сурталчлан, зөвлөгөө мэдээлэл өгч, Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, дүүргийн ажил хайгч 131 иргэнийг бүртгэж, 220 гаруй сул чөлөөтэй ажлын байр санал болгосон.</p>	90%
Гүйцэтгэлийн зорилт 1.4. Мэргэжлийн болон давтан сургалтад иргэдийг хамруулан, тохирох ажлын байранд зуучилна.							
1.4.1.	Ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжлийн болон давтан сургалтад хамруулан, ажлын байранд зуучлах		тоо	3405	275	<p>"Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр"-ийн Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад нийт 451 иргэн хамрагдахаар хүсэлт ирүүлснээс 352 иргэнийг 11 мэргэжлээр 15 сургалтын төвд мэргэжил эзэмших, ур чадварыг ахиулах сургалтад хамруулсан. Тус сургалтад хамрагдсан иргэдийн 30.1 хувь буюу 106 иргэн нь байнгын ажлын байртай болсон байна. Байнгын ажлын байртай болсон иргэдийн 82 хувь нь эмэгтэй, 18 хувь нь эрэгтэй суралцагч байна.</p>	90%

1.4.2	Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдах иргэдийн 40-өөс доошгүй хувь нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой мэргэжилгүй, ажлын туршлагагүй залуучууд байхаар зохион байгуулах	ХЭДС 125.0	Хувь	40%	40%	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт”-д хамрагдах хүсэлтэй иргэдийн эрэлтийг тодорхойлох, бүртгэх ажлыг төвийн 6 дүүргийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулж, 451 иргэний мэдээллийг авч нэгтгэсэн. Сургалтад нийт 352 иргэн хамрагдсан ба 215 нь буюу 47 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой иргэд байна.	90%
1.4.3.	Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа мэргэжил болон иргэдийн мэргэжлийн сургалтад хамрагдах эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгааг хийх.		тоо	1	1	Нийслэлийн 6 дүүргээс судалгаа авч, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй 10 мэргэжлийг тодорхойлсон. Үүнд: 1.Машин механизм, төхөөрөмжийн засварчин 2.Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр 3. Худалдагч касс, нярав 4. Талх нарийн боов 5.Хүнд машин механизмын оператор 6. Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан 7.Зочид буудлын үйлчлэгч, үйлчилгээний ажилтан 8. Барилгын туслах 9. Зөөгч,бармен 10. Жолооч	90%
1.4.4.	Мэргэжлийн ур чадварын уралдаан зохион байгуулах		тоо	-	1	“Монгол ур чадвар 2021” мэргэжлийн ур чадварын уралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Техник, Технологийн политехникийн коллеж болон Монгол Солонгосын политехникийн коллежтой хамтран зохион байгуулсан. Уралдаанд нийт 104 оюутан оролцсоноос амжилттай оролцож шалгарсан мужаан, сантехник, гагнуурчин, тогоочийн ангийн 13	70%

						оюутанд сургалтын төлбөрийн 30 хувийн хөнгөлөлтийн эрхийн бичгээр шагнасан.	
2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
Гүйцэтгэлийн зорилт 2.1.1. Байгууллагын ил тод байдлыг ханган ажиллана.							
2.1.1.1.	Байгууллагын дотоод зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах ажиллагааг хуулийн дагуу шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	-	хувь	100	100	Байгууллагын дотоод зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нийт 147 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивд хүлээн авснаас байнга хадгалах 45, түр хадгалах 96, 70 жил хадгалах 6 байна. Тус газарт нийт 33 өргөдөл ирж хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэгдсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 8 цаг 6 минут байна. Мөн нийт 623 /хариугүй 345, хариутай 278/ албан бичиг ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	90%
2.1.1.2.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх	-	хувь	100	100	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, хүний нөөцийн бодлого, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа тус бүрийн ил тод байдлыг ханган дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр: - Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн захиргааны болон	90%

					<p>үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актууд;</p> <p>- Газрын даргын “А” тушаалууд, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс тухайн онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, хөтөлбөрүүд, түүнд хэрхэн хамрагдах, талаарх мэдээллүүд;</p> <p>2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах чиглэлээр:</p> <p>- Газрын даргын “Б” тушаалууд “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”, байгууллагын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, албан хаагчдыг 2021 онд чадавхжуулах сургалтын төлөвлөгөө, байгууллагын бүтэц, хүний нөөц, албан хаагчдын нэр, албан тушаал, и-мэйл хаяг, холбоо барих утас зэрэг мэдээлэл</p> <p>3. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр:</p> <p>- Байгууллагын төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайлан болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт;</p> <p>-Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээг тухай бүр, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зэрэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд заасан хугацаанд тус тус байршуулан ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	---	--

Гүйцэтгэлийн зорилт 2.1.2. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг ханган ажиллана.							
2.1.2.1.	Байгууллагын тухайн жилийн төсөв, төсөвт оруулсан нэмэлт, өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл, төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн данс, мэдээллийн самбарт ойлгомжтой байршуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрэн ханган ажиллах	-	Хувь	100	100	Байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, төсвийн тухай хуулийн хэрэгжилт болон төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр: -Байгууллагын төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. -Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээг тухай бүр, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд заасан хугацаанд байршуулан ажиллаж байна.	90%
2.1.2.2.	“Төсвийн тухай” хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, ХЭДС-ийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах	-	хувь	100	100	ХХҮЕГ-аас 904,000,000.00 төгрөгийн орлого тус байгууллагын дансанд орж ирснээс 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 509,596,420 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг сар бүр, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах талаар гаргасан шийдвэрийг хуульд заасан хугацаанд https://info.shilendans.gov.mn/ -д оруулсан.	90%
2.1.2.3.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах	-	тоо	3	3	2021 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй болно.	-
Гүйцэтгэлийн зорилт 2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон цагийн болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ.							
						ХБХХЕГ-ын цахим хуудасны “Хөдөлмөрийн бирж” цэс болон байгууллагын цахим	

2.1.3.1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цахим хуудас ажиллуулах	-	тоо	-	1	хуудсанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажлын байрны зар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх 45 мэдээ, мэдээллийг байршуулж 36000 иргэний хандалт авсан байна.	90%
2.1.3.2.	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг ААНБ-д сурталчлан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлах	-	тоо	280	100	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж, Нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр, хадгаламжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран хяналт, шалгалтыг хийж, 231 байгууллагаас нийт 2,284,465,485 төгрөгийн төлбөр, торгуулийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн ажилласан. 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй, ажил хайгч 222 иргэнийг бүртгэн, 91 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан.	90%
2.1.3.3.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийсэн бүтээгдэхүүний "Бид бүгдийг чадна" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	-	тоо	-	1	- Нийслэлийн захирагчийн ажлын албатай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийсэн бүтээгдэхүүний "Бид бүгдийг чадна" үзэсгэлэн худалдааг 2021 оны 10 дугаар сарын 21-22-ны хооронд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд төвийн 6 дүүргийн 18 иргэнийг оролцуулж, нийт 1,136,000 төгрөгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт хийсэн. - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдөрт зориулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газраас зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нээлттэй ажлын байранд зуучлах " ЭЭЛТЭЙ ЭКСПО" өдөрлөгт хамтран оролцож, төвийн 6	90%

						дүүргээс хувиараа жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг 16 иргэн үзэсгэлэн худалдаанд оролцож, 237,000 мянган төгрөгийн борлуулалт хийж 500,000-600,000 төгрөгийн захиалга авсан байна.	
Гүйцэтгэлийн зорилт 2.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.							
2.1.4.1.	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг ханган ажиллах	Нийслэлийн төсөв 1.7	Хувь	100	100	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг угтан 2021 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулъя, ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан дор сарын аяныг зохион байгуулж, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/148 дугаар захирамжаар “Нийслэлийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулсан. - 4,000 ширхэг зөвлөмж /цар тахлын үед аюулгүй ажиллах зааварчилгаа, стандарт/, 5,000 ширхэг гарын авлага, хуанли зэргийг хэвлүүлж, иргэд, байгууллагууд, дүүргийн ХХҮХ-үүдэд тараасан. <p>2021 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 04, 17, 18, 20-ний өдрүүдэд Нийслэл Улаанбаатар хотын үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Нийслэлийн Ажил олгогч эздийн холбоотой хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэс” сэдэвт сургалтыг 5 удаа цахимаар зохион байгуулж, 384 ажилтныг хамруулсан.</p> <p>Цахим орчинд хууль тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах, соён гэгээрүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулж, 10 гаруй төрлийн постер, 20 гаруй төрлийн зурагт</p>	90%

						танилцуулгыг түгээн ажилласан. Хөдөлмөрийн харилцааны маргаан, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ болон бусад асуудлаар 14 иргэнд зөвлөгөө өгч, холбогдох эрх бүхий байгууллагуудын мэдээллийг хүргэсэн.	
2.2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
Гүйцэтгэлийн зорилт 2.2.1. "Бүх шатанд мэргэшсэн албан хаагчидтай байж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, ил тод, нээлттэй, тэгш зарчмыг баримтлан хүргэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэх" арга хэмжээг зохион байгуулж, тайлагнана.							
2.2.1.1.	Төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулах	ХЭДС 15.0	тоо	20	20	Төрийн захиргааны эрхэлсэн, ахлах түшмэлийн ангиллын албан тушаалд ажиллаж байгаа болон төрийн албанд анх томилогдсон албан хаагчдын судалгааг гарган, богино, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулахаар 3 албан хаагчийн мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	50%
2.2.1.2.	Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, ур чадварыг тогтмол дээшлүүлэх	-	тоо	20	20	Ажилтан, албан хаагчдын мэргэшил, ур чадварыг сайжруулах зорилгоор сургалтын хэрэгцээний судалгаа авсны дагуу чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр батлуулан хэрэгжүүлсэн. Тус байгууллага нь 20 албан хаагчтай бөгөөд тайлант хугацаанд давхардсан тоогоор 258 албан хаагчийг салбарын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн ёс зүй, архив, албан хэрэг хөтлөлт болон бусад чиглэлээр зохион байгуулагдсан 78 төрлийн /368 цаг 30 минут/ сургалтад хамруулсан байна.	90%
2.2.1.3.	Байгууллагын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө гарган, батлан хэрэгжүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх	-	тоо	20	20	Газрын дарга 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө"-г баталсны дагуу хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:	90%

					<ul style="list-style-type: none"> - Газрын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар албан хаагчдын цалин нэмэгдэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4, албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 3, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 1, албан тушаалын шатлалыг 5 албан хаагчид тус тус ахиулан олгосон - Даргын тушаалаар тус газарт тогтвор суурьшилтай ажилласан 3 мэргэжилтний албан тушаалыг ахиулан, ахлах мэргэжилтнээр томилон ажиллуулсан - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр, Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ой, Улс тунхагласны баярын өдрүүдийг тус тус тохиолдуулан 6 албан хаагчийг шагнан урамшуулсан. - Газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар “Албан хаагчдын 2021 оны ээлжийн амралтын хуваарь”-ийг баталсны дагуу нийт албан хаагчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлсэн. - Газрын даргын 2021 оны А/04, А/25 дугаар тушаалуудаар сар шинийн баяр болон ахмадын өдрийг тус тус тохиолдуулан өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. - Газрын даргын 2021 оны Б/07, Б/08, Б/23 дугаар тушаалуудаар 2 албан хаагчид тус бүр ажлын 23 өдрийн, 1 албан хаагчид 7 өдрийн цалинтай чөлөө олгосон. - Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 албан хаагчийн суурин компьютерыг шинэчилсэн - Оффисын нийт 460м2 талбайд 6
--	--	--	--	--	---

					<p>удаагийн давтамжтай ариутгал халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн ба албан хаагчдыг маск, гар ариутгагчаар хангасан.</p> <p>Үйл ажиллагааны хүрээнд 2 албан хаагч албаны унаа ашигладаг ба нийт албан хаагчдад хоол, унааны нэмэгдлийг сар бүр тогтмол олгосон.</p> <ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын цахим хаягаар цалин, нэмэгдэл, суутгал, шимтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг сар бүр тогтмол хүргүүлсэн. - Албан хаагчдыг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшлоор хангасан. - Дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түргэн шуурхай мэдээлэл солилцох, цаасны хэрэглээг багасгах зорилгоор UB ERP, Edoc, Jitem, Ework системүүдэд нийт албан хаагчдыг бүртгэлжүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. - Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээнд хамрагдах шаардлагатай 4 албан хаагчид шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлсэн. - 2021 оны 03 дугаар сард “Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” арга хэмжээнд нийт албан хаагчдыг хамрагдахыг уриалж, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, алхалт, гүйлтээр хичээллэн, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн хийх, эрүүл амьдралын дадал хэвшилд суралцахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Тус арга хэмжээнд нийт 10 албан хаагч оролцож, нийт 225,46 километр гүйсэн. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Мэргэжлийн өвчин 	
--	--	--	--	--	---	--

						судлалын газарт тус байгууллагын 19 албан хаагчийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 8 төрлийн шинжилгээнд хамруулсан.	
2.2.1.4.	Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх, ажилтнуудын төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүй, ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сахиулж, хяналт тавьж, ажиллах	-	Хувь	100	100	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм болон холбогдох бусад хууль, эрх зүйн актад үндэслэн Газрын даргын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан. Журамд төрийн албан хаагчийн ёс зүй, эрх, үүрэг, хөдөлмөрийн сахилга, хариуцлага, ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, хууль тогтоомжийг мөрдөн ажиллах талаар нарийвчлан тусгасны дагуу хэрэгжилтэд хяналт тавин ажилласан бөгөөд байгууллагын албан хаагчдад холбогдох аливаа ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй болно.	90%
Гүйцэтгэлийн зорилт 2.2.2. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.							
2.2.2.1.	Цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчилж, баяжуулах, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах	-	Хувь	100	100	Байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn вэб сайтад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл, хүний нөөцийн ил тод байдлыг олон нийтэд нээлттэй байдлаар байршуулж, нэмэлт, өөрчлөлт орох бүрд мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Тус газрын www.ubbirj.ub.gov.mn сайтаар байгууллагын танилцуулга, видео, хууль тогтоомж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр,	90%

						цаг үеийн мэдээ мэдээлэл, нийтлэл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зар мэдээ зэрэг нийт 200 гаруй мэдээлэл оруулсан нь 367,679 хандалт авсан байна.	
2.2.2.2.	Байгууллагын компьютер, принтер, техник, тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах	-	Тоо	40	40	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 албан хаагчийн суурин компьютерыг шинэчилсэн ба нийт албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшлоор хангаж, бүх албан хаагчдын компьютерт ESET NO32 антивирусын 1 жилийн эрхтэй программ суулгасан. Интернэтийн сүлжээ дамжуулах төхөөрөмжийг шинэчилсэн бөгөөд хэвийн ажиллагаагаар ханган, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллалаа.	90%
2.2.2.3.	Байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, мэдээллийг баяжуулж цахим сан бүрдүүлэх	-	Хувь	100	100	Байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түргэн шуурхай мэдээлэл солилцох, цаасны хэрэглээг багасгах зорилгоор UB ERP, Edoc, Ework, LMIS, Job Opensoft системүүдэд нийт албан хаагчдыг бүртгэлжүүлж, мэдээллийг тухай бүр баяжуулан, тогтмол ашиглаж хэвшсэн.	90%
Гүйцэтгэлийн зорилт 2.2.3. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулна.							
2.2.3.1.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, агентлагийн үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, хийсэн ажлын тайланг иргэд, олон нийтэд үр ашигтай, хүнд сурталгүй, шуурхай хүргэн ажиллах	-	хувь	100	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, авилгаас урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжууд, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрүүд, түүнд хэрхэн хамрагдах, талаарх мэдээллүүд, албан хаагчдын мэдээллүүдийг байгууллагын вебсайт, фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэсэн.	90%

						Мөн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 10 телевиз, 4 радиотой хамтран ажиллаж, цаг үеийн мэдээ, мэдээллийг дамжуулсан.	
Гүйцэтгэлийн зорилт 2.2.4. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлнэ.							
2.2.4.1.	Байгууллагын тушаал, шийдвэр, дүрэм, журам, гэрээ, хэлцэл, эрх зүйн баримт бичгийг хуульд нийцүүлэн боловсруулахад хяналт тавих, хууль ёсны эрх ашгийг шүүх болон бусад байгууллагад төлөөлөн ажиллах	-	хувь	100	100	2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаа болон хүний нөөцийн үйл ажиллагааны хүрээнд гарсан нийт 64 тушаал, төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах зорилгоор байгуулсан 105 гэрээний төслийг эрх зүйн асуудал хариуцсан албан хаагч хянаж, дугаар олгон ажиллалаа.	90%
2.2.4.2.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах, биелэлтийг ханган ажиллах	-	хувь	100	100	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Үүний хүрээнд “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр батлан хэрэгжүүлж, биелэлтийг холбогдох газарт хүргүүлсэн. Мөн ХАСХОМ гаргагч албан тушаалтнуудыг байгууллагын ЭБАТ арга зүйгээр ханган ажиллаж, нийт 15 ХАСУМ болон ХАСХОМ-үүдийг хуулийн хугацаанд meduuleg.iaac.mn цахим хуудсанд баталгаажуулан ажилласан.	90%
Гүйцэтгэлийн зорилт 2.2.5. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод хяналт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах							
2.2.5.1.	Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайлагнах	-	хувь	100	100	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн дагуу Засгийн газрын 1 дүгээр тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 хурлын тэмдэглэлийн	90%

						биелэлт болон холбогдох бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн хамт НЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллав.	
2.2.5.2.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллах	-	хувь	100	100	<p>Тус байгууллага нь 2021 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, бэлтгэл ажлууд болоод хэрэгжилтийг ханган ажиллахад хяналт хийлээ. Үүнд:</p> <p>1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн Танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:</p> <p>- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан, сургалтын байгууллагуудад УОК-ын А/41 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах түр журамд заасны дагуу 10 хүртлэх суралцагчтайгаар мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулдаг сургалтын байгууллагуудаар Нийслэлийн Онцгой комиссын гишүүдтэй 2021 оны 05 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд төвийн 6 дүүргийн хэмжээнд хяналтаар явж, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэсэн. Шалгалтаар явахдаа ковид-19 халдварын талаарх мэдээлэл, ариутгал халдваргүйжүүлэлт болоод тоног төхөөрөмж, сургалтын ширээнүүдийн хоорондын зай, өрөө тасалгааны агаар сэлгэлтийн талаар зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.</p> <p>- “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн Хөдөлмөрт бэлтгэх танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээний хүрээнд хүсэлтээ ирүүлсэн 15 сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалт зохион байгуулах дадлагын болон онолын</p>	90%

						байрны тохижилт, халдвар хамгааллын дэглэм баримталж байгаа зэрэгт хяналт хийж, сургалтын байгууллага сонгон шалгуулах ажлын хэсэгт орж ажилласан. Арга хэмжээний хэрэгжилт 90% 2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээний хүрээнд: Арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудын гүйцэтгэлд явцын хяналт хийж ажиллав. Арга хэмжээний хэрэгжилт 90% 3. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 3 удаа, Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт хийн ажиллав. Арга хэмжээний хэрэгжилт 90% Нийт жилийн эцсийн байдлаар 3 аж ахуй нэгж байгууллага, 15 сургалтын төвд хяналт шалгалт хийж ажиллаа.	
2.2.5.3.	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хийн, удирдах дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг чиглэл, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, хугацаанд нь тайлагнах	-	хувь	100	100	Тогтоол шийдвэр болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан журмуудыг мөрдлөг болгон, үнэлэх аргачлалыг баримтлан ажиллаж байна.	90%
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хөндлөнгийн	ХЭДС 11.0	Тоо	1	1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт-	

2.2.5.4.	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх					шинжилгээ, үнэлгээг жил бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хөтөлбөрүүдийн хэрэгжилт удааширсан тул хөндлөнгийн үнэлгээг 2021 оны 12 дугаар сард хийлгэхээр төлөвлөж байна.	30%
2.2.5.5.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	ХЭДС 4.5	Тоо	4	4	2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн зөвлөл цахимаар хуралдаж, 2021 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээний төсвийг хэлэлцэн баталсны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.	90%
2.2.5.6.	Эд хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах	-	Эд хөрөнгийн тооллогын тоо	2	2	Эд хөрөнгийн 2021 оны тооллого зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан Байгууллагын эд хогшил, тоног, төхөөрөмж, УБ агропарк дахь хөрөнгийг тоолох, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хүлэмж, тоног төхөөрөмжийг актлах ажлыг хийж, тооцоо, судалгааг гаргасан. Тооллогоор тус газрын эд хариуцагч нар болон аж ахуйн няравт бүртгэлтэй 2960 нэр төрлийн нийт 617,794,000.00 /зургаан зуун арван долоон сая долоон зуун ерэн дөрвөн мянга/ төгрөгийн үндсэн хөрөнгө тоолов. Үүнд: ✓ Тавилга эд хогшил 68,776,800 ✓ Тоног төхөөрөмж 102,536,300 ✓ Авто тээврийн хэрэгсэл 80,312,500 ✓ Бусад биет бус хөрөнгө 13,000,000 ✓ Бусад үндсэн хөрөнгө 283,538,400 ✓ Программ хангамж 69,630,000	90%
3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
Гүйцэтгэлийн зорилт 3.1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг олон улсын жишигт нийцүүлж, бүсчилсэн байдлаар хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэсэн байна.							

3.1.1.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	Нийслэлийн төсөв 400.0	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн тоо	1	1	<p>1. Газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг төв байгуулах байршил болон байр танхим, шаардлагатай эд хогшил, техник, тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гарган, 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр удирдлагад танилцуулсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол гарсантай холбогдуулан шинээр төв байгуулах ажил зогссон.</p> <p>2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь MNS:6620-2016 стандартын дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр эрхлэлтийн 9 төрлийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлж байна.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 711 ажил олгогчийн 7966 ажлын байрны захиалгыг төвлөрүүлж, давхардсан тоогоор нийт 29464 иргэн, ажил олгогчид дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүртгэсэн ажил хайгч иргэн 2455 - Ажлын байранд зуучилсан иргэн 5701 /үүнээс ажилд орсон 3921/ - Цахим өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо 273 - Дундын оффисоор үйлчлүүлсэн иргэн 656 - Хүүхдийн өрөөгөөр үйлчлүүлсэн иргэн 112 - Шийдвэрлэсэн санал хүсэлт 1059 - АМЧБО бүлгийн сургалтад хамрагдсан иргэн 2181 - АМЧБО ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэн 4991 	90%
			Төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо	23633	25000		
			Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо	14310	15000		

						<p>Цахим үйлчилгээ авсан иргэний тоо 653772</p> <ul style="list-style-type: none"> • НХЭГ, ХЭДТ фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлэл авсан иргэний тоо 652188 • Цахим зуучлалын үйлчилгээ авсан ажил олгогчийн тоо 173, • иргэний тоо 3123 • UB job аппликэйшнээр үйлчилгээ авсан иргэний тоо 105 • Хөдөлмөрийн эрхлэлтийн мэдээ мэдээллийг хүргэсэн иргэний тоо 659659 <p>3. Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв болон дүүргийн ХХҮХ-үүд ажилд зуучлах үйлчилгээг үзүүлж, ажил хайгч 11870 иргэнийг тохирох ажлын байранд зуучилснаас 10121 иргэн ажилд орсон байна.</p>	
3.1.2	Мэргэжилтнүүдийг олон улсын жишигт нийцсэн сургалтад хамруулан мэргэшүүлэх		Тоо	20	20	<p>Швейцарын хөгжлийн агентлаг, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс зохион байгуулсан “Хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээний сургагч багш бэлтгэх сургалт”, БНХАУ-аас МУ-д суугаа ЭСЯ-наас зохион байгуулсан “Хөгжиж байгаа орнуудын төрийн үйлчилгээ ба ядуурлыг бууруулах нь” зэрэг олон улсын жижигт нийцсэн сургалтуудад холбогдох мэргэжилтнүүдийг тус тус хамруулан чадавхжуулсан.</p> <p>Тус байгууллага нь 20 албан хаагчтай бөгөөд тайлант хугацаанд давхардсан тоогоор 258 албан хаагчийг салбарын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн ёс зүй, архив, албан хэрэг хөтлөлт болон бусад</p>	90%

						чиглэлээр зохион байгуулагдсан 78 төрлийн /368 цаг 30 минут/ сургалтад хамруулсан байна.	
3.1.3.	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулан иргэд аж ахуй нэгж байгууллагад нэг дороос хүргэх		хувь	100	100	<p>Нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад дараах байдлаар үйлчилгээ үзүүлж ажиллав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бүртгэсэн шинэ ажлын байр 6961 • Ажлын байрны захиалга 19667 • Түр ажлын байр 838 • Цагийн ажлын байр 6139 • Бүртгэсэн ажил хайгч иргэн 14290 • Ажилд зуучилсан иргэн 11870 • Ажилд орсон иргэн 10121 • Ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон иргэн 25713 • Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэн 3689 • Бүртгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн 233 • Зуучилсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн 113 • Ажилгүйдлийн тэтгэмж хүссэн иргэн 13026 байна. 	90%
Гүйцэтгэлийн зорилт 3.2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг зохион байгуулна.							
3.2.1.	Иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хүргэх арга хэрэгслийг хөнгөвчлөх, бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо	223000	220000	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөвчлөх зорилгоор ажил олгогч болон ажил хайгч иргэнд зориулан тус байгууллагын https://job.opensoft.mn/ бүртгэлийн системтэй холбогдсон UB JOB гар утасны аппликейшнийг нэвтрүүлж, хэрэглээг жигдрүүлэх зорилгоор өөртөө үйлчлэх хэсэг байгуулж, 2 ширхэг таблет суурилуулсан.	90%

						<p>Бүртгэл, мэдээллийн системийн сурталчилгаа, шаардлагатай нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг тухай бүр хийж байна.</p> <p>Байгууллагын албан ёсны www.ubbirj.ub.gov.mn цахим хуудас, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” болон “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” пэйж хуудсаар 367679 иргэнд, 131896 тусгай дугаарын www.smsservice.opensoft.mn/ үйлчилгээгээр 21590 иргэнд, цахим зуучлалын үйлчилгээгээр 173 ажил олгогч, 3105 иргэнд, UB JOB аппликейшнаар 123 иргэнд, нийт 659659 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.</p>	
3.2.2.	Ажилгүй иргэдийг бүртгэн, ажлын байранд зуучилж хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээлийн санд оруулах	ХЭДС 34.5	Бүртгүүлсэн иргэдийн тоо	21953	20000	<p>1. Нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд “Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем” /LMIS/-д ажил хайгч иргэн 14290, ажилд зуучилсан иргэн 11870, ажилд орсон иргэн 10121, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан 25713 иргэнийн мэдээллийг тус тус тухай бүр бүртгэж оруулсан.</p> <p>2. Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв болон дүүргийн ХХҮХ-үүд ажилд зуучлах үйлчилгээг үзүүлж, ажил хайгч 11870 иргэнийг тохирох ажлын байранд зуучилснаар 10121 иргэн ажилд орсон.</p> <p>Ажилд орсон иргэдийн мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем /LMIS/-д тухай бүр бүртгэн ажиллав.</p>	90%
3.2.3.	Зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх,	ХЭДС 54.0	Тоо	17487	15000	<p>Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд зорилтот бүлгийн 25713 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд</p>	90%

	мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах					хамруулсан байна. Эрх бүхий хөдөлмөрийн биржтэй хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг 2021 оны 06 дугаар сараас үе шаттай зохион байгуулан ганцаарчилсан хэлбэрээр 85875, бүлгээр 106385 иргэнийг тус тус хамруулан ажиллалаа.	
Гүйцэтгэлийн зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулна.							
3.3.1.	Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах	ХЭДС 42.0	Тоо	-	150	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021 онд баталсан “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан нийт 2265 иргэнийг хамруулж түр ажлын байраар хангасан. Тус байгууллага нь нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 158 иргэнийг хамруулсан.	90%
3.3.2.	Гэрээт малчин арга хэмжээ зохион байгуулах	ХЭДС 400.0	Тоо	-	100	“Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээний хүрээнд гэрээт малчин өрх, ажил олгогч малчны судалгааг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудаас авсан. Тус арга хэмжээний хүрээнд гэрээт малчнаар ажиллах хүсэлтэй 67 иргэн, гэрээт малчин ажиллуулах хүсэлтэй 265 малчны судалгааг авч нэгтгэхэд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 7 хувь нь буюу 5 иргэн нь гэрээт малчнаар ажиллах хүсэлт гаргасан боловч ажил олгогч малчинтай гэрээний нөхцөл тохироогүй улмаас татгалзсан. “Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээний танилцуулга, мэдээллийг ubbirj.ub.gov.mn ,	70%

						ulaanbaatar.mn, “Нийслэлийн мэдээ” фэйсбүүк хуудас, “MGL RADIO” FM 88,3 зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан сурталчилж, ХЭДС-аас 293.400 төгрөгийг зарцуулсан.	
3.3.3.	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн өдөрлөг яармаг, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	ХЭДС 20.0	Тоо	23	9	2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 18 удаа хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, 11 удаа ажлын байрны өдөрлөг, яармаг зохион байгуулж, 20-с дээш ажлын байр зарласан томоохон ажил олгогчтой хамтран ажилласан байна.	90%
3.3.4.	Гарын авлага тараах материал хэвлэмэл хуудас бэлтгэх, хэвлүүлэх	ХЭДС 10.0	Тоо	10000	10000	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2021-2022 онд хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн танилцуулга 2000 ширхэг, Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээний танилцуулга, гарын авлага 5950 ширхэг, “Цар тахлын үед аюулгүй ажиллах зааварчилгаа, стандарт, зөвлөмж” 4000 ширхэг, ХАБЭА-н мэдээлэл бүхий хуанли 5000 ширхэгийг тус тус хэвлүүлсэн ба холбогдох албан байгууллага, дүүрэг хороодоор дамжуулан иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.	90%
Гүйцэтгэлийн зорилт 3.4. Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг богиносгох замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах мэдээлэл, нөлөөллийн аян зохион байгуулна.							
3.4.1.	Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг богиносгох замаар байгууллагын урсгал зардлыг бууруулах нөлөөллийн аян зохион байгуулах	-	тоо	-	3	Хөдөлмөрийн цахим яармаг 2021 арга хэмжээнд “Номин холдинг” ХХК-ийн хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Оюунболорыг урьж оролцуулан, ажлын цагийг богиносгосон туршлагын талаар олон нийтэд танилцуулга, мэдээллийг хүргэсэн. Тус илтгэлийг 1500 иргэн www.expomongolia.org платформын шууд дамжуулалтаар хүлээн авч үзсэн.	90%
Гүйцэтгэлийн зорилт 3.5. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах өдөрлөгийг тогтмол зохион байгуулна.							
3.5.1	Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудтай	-	тоо	1	2	Жил бүр Монголд улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран	

	хамтран хөдөлмөрийн өдөрлөг, яармагийг зохион байгуулах					хөдөлмөрийн өдөрлөг, яармагийг зохион байгуулж ирсэн. Гадаадад өндөр мэдлэг ур чадвар эзэмшсэн иргэд, гадаадад ажиллаж байгаад ирсэн иргэдийг ажилд авах хүсэлтэй ажил олгогч нарт зориулсан өдөрлөгийг 3 удаа зохион байгуулсан ба тус өдөрлөгөөр 65 иргэнийг ажлын байранд зуучлан, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.	90%
3.5.2.	Гадаадад их дээд сургууль төгсөгчид, ажил мэргэжлийн туршлагатай эх орондоо эргэн ирсэн өндөр боловсролтой иргэдийг ажлын байранд зуучлах, өдөрлөг зохион байгуулах		тоо	1	1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэвшүүлсэн халамжаас хөдөлмөрт зорилтын хүрээнд “ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАМТДАА” Хөдөлмөрийн цахим яармаг-2021 арга хэмжээг ХНХЯ, ХХҮЕГ, МАОЭНХ, МҮХАҮТ, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллага, “Эйч Ар клуб” ТББ хамтран 2021 оны 05 дугаар сарын 08-24-ний өдрүүдэд www.expomongolia.org платформоор зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд өдөр бүр цахим хурлуудыг зохион байгуулснаас гадна нийт 183 ажил олгогч байгууллагын 2126 сул чөлөөтэй ажлын байрны мэдээ, мэдээллүүдийг ажил хайгч иргэд, оюутан залуучууд, гадаадад их дээд сургууль төгссөн болон ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэдэд нэг дороос хүргэсэн. Платформд ажил хайгч иргэн болон ажил олгогчид 273 ярилцлагын цаг товлон, ажлын шууд ярилцлага зохион байгуулсан.	90%
Гүйцэтгэлийн зорилт 3.6. Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудад зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.							
3.6.1.	Зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголтыг ААНБ, ажил олгогч нарт сурталчлан	-	тоо	-	3	Хөдөлмөрийн цахим яармаг 2021 арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батцэцэг, Монголын ажил олгогч эздийн	90%

	таниулах ажлыг зохион байгуулах					нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар нарыг урьж оролцуулан, “Төрөөс баримтлах хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт ба зохистой хөдөлмөр эрхлэлт”, “Зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаар анхаарах асуудал” сэдвүүдээр тус тус олон нийтэд танилцуулга, мэдээллийг хүргэсэн. Тус илтгэлүүдийг нийт 5600 иргэн www.expomongolia.org платформын шууд дамжуулалтаар хүлээн авч үзсэн.	
Гүйцэтгэлийн зорилт 3.7. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр, инновацыг дэмжин санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар аж ахуй, бичил, жижиг, дунд бизнесүүдийг албан хэвшилд шилжүүлж, өсөлтийг дэмжинэ.							
3.7.1.	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг бичил бизнес эрхлэгч иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-	тоо	-	500	Мөн хөтөлбөрт хамрагдсан хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдэд “Хоршоо 152” фэйсбүүк хуудсаар дамжуулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн талаар 8 нийтлэл хүргэснийг 458 иргэн уншиж, танилцсан байна.	90%
3.7.2.	Цахим сургалт, цахим худалдаа, цахим маркетинг зэрэг шинэлэг ажил үйлчилгээг нэвтрүүлэх	-	хувь	-	100	Олон Улсын Хөгжлийн Агентлаг “Best” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Төсөл бичих аргачлал” 16 цагийн цахим сургалтад “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд хамтран ажилладаг 50 хадгаламж зээлийн хоршооны 471 гишүүнийг хамруулсан.	90%
Гүйцэтгэлийн зорилт 3.8. Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.							
3.8.1.	Албан бус салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран эрүүл мэнд, нийгмийн даатгал хуулийг сурталчлан ажиллах	Нийслэлийн төсөв 100.0	Албан бус хөдөлмөр эрхэлж буй иргэний тоо	11000	5000	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын сургалт судалгааны төвтэй хамтран албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн албан салбарт шилжихэд нөлөөлөх нөлөөллийн сургалтыг эрүүл мэнд, нийгмийн даатгал гэсэн сэдвээр 2021 оны 11 дүгээр сарын 02-ний өдрөөс 25-ний өдрүүдэд нийт 12 удаа цахимаар зохион байгуулсан.	90%

3.8.2.	Худалдаа, үйлчилгээний салбарт албан бусаар хөдөлмөр эрхэлж буй иргэдэд албан хөдөлмөр эрхлэлтийн ач холбогдлыг таниулах сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах		хувь	-	100	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/728 дугаар захирамжийн дагуу албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн албан салбарт шилжихэд нөлөөлөх нөлөөллийн сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 02-ний өдрөөс 25-ний өдрүүдэд нийт 12 удаа цахимаар зохион байгуулсан. Тус сургалтад төвийн 6 дүүргийн 157 хорооны 2704 иргэнийг хамруулсан.	90%
Үнэлгээ						90 хувьтай – 50 арга хэмжээ 70 хувьтай – 2 арга хэмжээ 50 хувьтай – 1 арга хэмжээ 30 хувьтай – 1 арга хэмжээ Хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээ Дундаж үнэлгээ: 54 заалт 87.4% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”	